

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ
2022 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр

№	Хийсэн ажил /чиглэлээр/	Гүйцэтгэсэн ажлын төрөл дараахь 4-н аль нэгийг сонгож (√) тэмдэглэгээ хийх			
		Тулгамд- сан ажил	УИХ, ЗГ-т өргөн барьсан	Салбарын хүрээнд хийгдсэн	Шинэлэг ажил
I	Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр				
1.	Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг ЗГХЭГ-ын даргад 2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр танилцуулж, хэлэлцүүлэв.		√		
2.	УИХ, НББХ-ноос зохион байгуулсан төр, хувийн хэвшил болон Олон улсын байгууллагын төлөөллүүдийн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн хэлэлцүүлэгт тус яамны холбогдох газрын дарга, мэргэжилтнүүд оролцов.		√		
3.	УИХ-ын 2022 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайдын хийх мэдээллийн жагсаалтад Цалин, хөлсний шинэчлэл, Нийгмийн даатгалын шинэчлэл, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, цаашид авах арга хэмжээний саналыг тусгуулахаар хүргүүллээ.		√		
4.	“Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” болон “Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын 2022 оны 52 дугаар тогтоолд тусгагдсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн төслийн боловсруулалтын явцын талаарх мэдээллийг бэлтгэн ЗГХЭГ-т 2022 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 1/2249 тоот албан бичгээр хүргүүлэв.		√		
5.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгаар АХБ-ны техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр Монголын улаан загалмай нийгэмлэг (МУЗН) нь 2022 оны 6 дугаар сараас 2023 оны 12 дугаар сарыг дуустал нийт 18.5 сарын хугацаанд “Төгсөлтийн аргачлалаар хэрэгжүүлэх туршилтын төсөл”-ийг хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Уг туршилтын төсөлд СХД, БЗД, ЧД-ийн 28 хороодод хүнсний эрхийн бичигт хамрагддаг нийт 1520 өрхийг нөхцөл байдал болон эмзэг байдлын оролцооны үнэлгээнд суурилан гаргасан өрх сонгох болон хөтөлбөрт хамрагдах шалгууруудын дагуу сонгохоор төлөвлөж байна. Өрхийн судалгаа авах ажил нь 2022 оны 8 дугаар сарын 8-29-ний өдрүүдэд 4200 өрхөөр айлчлан зорилтот өрхийг баталгаажуулах судалгааг нийт 35 судалгааны баг гарч ажиллав. Өрхийн судалгааны үр дүнг 3 дүүргийн Засаг дарга нартай хэлэлцэн, дахин баталгаажуулах алхмыг хийснээр эцэслэн сонгох ба одоогоор төслийн баг БЗД, СХД дүүрэг, хороодын Засаг дарга нар, нийгмийн ажилтнуудад төслийн талаар мэдээлэл өгч, хамтран ажиллах чиглэлийг танилцуулаад байна.			√	
6.	Ахмад настны үндэсний төвийн бүтцийн нэгжид Сувилахуйн төв гэсэн нэгж оруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсантай холбогдуулан Эрүүл мэндийн яам руу тус төвд тусгай зөвшөөрөл олгох хүсэлтийг 2022 оны 8 дугаар сард цахимаар хүргүүлэв.			√	
7.	“Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам”-ын төслийг боловсруулан СЯ, ХЗДХЯ, ЭМЯ болон цахим хэлбэрээр үндэсний хэмжээнд хэлэлцүүлж, шаардлагатай саналыг тусган, төслийг эцэслэсэн. Журмын төслийг ХЗДХЯ, ЭМЯ-нд хамтарсан тушаалаар батлуулахаар ХНХ-ын дэд сайдын 2022 оны 3/2497 албан тоотоор хүргүүлээд байна.			√	
8.	Гэр бүлийн тухай шинэчилсэн найруулгын хуулийн төслийн хэлэлцүүлэг 2 удаа зохион байгуулагдаж, хэлэлцүүлэгт ажлын хэсгийн гишүүдээс гадна өрх толгойлсон ээж, аавуудын төлөөллийг оролцууллаа.			√	
9.	Гэр бүл цуцлалтын гол шалтгааны нэг болох гэр бүлээс гадуурх харилцаанд төрөөс хэрхэн оролцож, хариуцлага тооцдог эсэх талаар гадаад орны туршлагыг судалж, мэдээлэл РРТ, хуулийн төсөлд тусгах асуудлын зөвлөмж бэлтгэв.	√			

10.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах олон улсын тэмдэглэлт өдрүүдийг Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”-д тусгуулах саналыг боловсруулан Соёлын яам руу хүргүүлэв.			√	
11.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийн автомашиныг дугаарын хязгаарлалтаас чөлөөлөх тухай саналыг боловсруулан ХЗДХЯ, НЗДТГ-т хүргүүлэв.				√
12.	-ГХЯ-наас ирүүлсэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даан амьдрах, нийгэмд оролцох эрхийг хангах үйлчилгээг сайжруулахад тулгамдаж буй асуудал, хэрэгжүүлж буй сайн туршлага” гэсэн НҮБ-ын асуулгын хариулыг боловсруулав. -Дотоодын хууль тогтоомжийг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын зүйл, заалттай нийцүүлэх санал боловсруулж байна.			√	
Бодлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр					
13.	2023 оны төсвийн төсөлд төрийн албаны цалин хөлсний тогтолцоог шинэчлэх 7 арга хэмжээг тусгаж холбогдох тооцоо, судалгаа хийж Сангийн яаманд хүргүүлэв. Тус арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд Төрийн албаны тухай хууль, УИХ-ын 2 тогтоол, Засгийн газрын 4 тогтоолд өөрчлөлт оруулж, УИХ-ын 2 тогтоол, Засгийн газрын 5 тогтоолыг хүчингүй болгон Засгийн газрын 3 тогтоол шинээр гаргах бөгөөд холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулав.			√	
14.	“Хөдөлмөрийн сонирхлын маргааныг хөдөлмөрийн зуучлагчийн дэмжлэгтэйгээр зохицуулах журам”, “Хөдөлмөрийн арбитрын дүрэм”-ийг батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авахад бэлэн болгов.			√	
15.	“Хөдөлмөрийн арбитрын дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын 2001 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 55 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцохоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан, үзэл баримтлалын төслийг батлуулахаар ХЗДХЯ-нд хүргүүлэв.			√	
16.	Нийгмийн Бодлогын байнгын хорооны хуралд Нийгмийн халамжийн тухай хууль болон “Халамжаас-Хөдөлмөрт” чиглэсэн ядуурлаас гаргах, тогтвортой амьжиргааг дэмжих, аргачлал хөтөлбөрийн талаарх холбогдох мэдээллийг бэлтгэн хүргүүлэв.		√		
17.	Олон улсын валютын сангийн хүрээнд “Монгол Улстай хийх 2022 оны зөвлөлдөх хэлэлцүүлэг”-т нийгмийн даатгалын чиглэлээр холбогдох тайлбар, мэдээллийг бэлтгэн хүргүүлэв.			√	
18.	Засгийн газрын хуралдаанд танилцуулах Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт шинэчлэл хийх 3 гол ажлын талаархи мэдээллийг бэлтгэн ЗГХЭГ-т хүргүүлэв.		√		
19.	Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төслийн хүрээнд Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлтэй холбоотой тооцоо судалгааг хийлгэхээр олон улсын зөвлөлтэй хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд холбогдох тоон мэдээлэл, судалгааг гаргаж хүргүүлэхээр бэлтгэж байна.			√	
20.	Европын Холбооны ТАИЕХ хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан хуучин социалист байсан зарим улсын нийгмийн даатгал ба тэтгэврийн тогтолцооны шинэчлэлийн талаарх сургалт хэлэлцүүлэгт тус яамны холбогдох газрын дарга, ахлах шинжээч нар 2022 оны 09 дүгээр сарын 12-14-ний өдрүүдэд оролцлоо.			√	
21.	НҮБ-ын Хүүхдийн сан, Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын уулзалтад Нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн талаарх мэдээлэл хийж, тус байгууллагуудын жилийн төлөвлөгөөнд тусгах санал хүргүүлэв.			√	
22.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиалгаар Азийн хөгжлийн банкны (АХБ) техник, санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Төгсөлтийн аргачлалаар хэрэгжүүлэх туршилтын төсөл”-ийн хүрээнд төсөлд хамрагдах 1520 өрхийг сонгох болон хөтөлбөрт хамрагдах шалгуурын төсөлд санал, зөвлөмж өгч ажиллав. Өрхтэй ажиллах коуч болон хорооны нийгмийн ажилтанд зориулсан сургалтыг зохион байгуулав.			√	
23.	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ЖАЙКА)-ийн 2022 онд Монгол Улсад хэрэгжүүлэх техникийн хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрт шалгарсан “Зорилтот бүлгийн иргэдийг бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх” төслийн ерөнхий зураглал, хэрэгжүүлэх нөхцөл боломжийг судлах хүрээнд ирсэн судалгааны багийнхантай санал солилцох уулзалт, хэлэлцүүлгийг яам, агентлагийн түвшинд 2022 оны 9 дугаар сарын 22-с 10-р сарын 04-ний өдрүүдэд зохион байгуулж байна.			√	
24.	Нийгмийн халамжийн чиглэлээр 4 агуулгын хүрээнд 20 модуль хөтөлбөрөөр онлайн сургалтын агуулгыг нэр төрөл, хугацаа, хамрагдах албан хаагчдын мэдээллийг хэрэгжүүлэх байгууллагад			√	

	тавих шалгуурын хамт боловсруулж, ажлын даалгаварт тусгуулан Дэлхийн банкны төслийн зөвлөхөд хүргүүлэв.				
25.	НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пактын хэрэгжилтийн талаарх 4 дүгээр тайлангийн хамгаалалттай холбоотой нийгмийн халамжийн чиглэлийн зорилтын биелэлтийг гаргав.			√	
26.	Орон нутгийн харьяалалтай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврийн хэрэгслээр 2017-2022 оны 8 сар хүртэл үйлчлүүлсэн зардлыг /өр төлбөр 1,0 тэрбум төгрөг/ шийдвэрлэх талаар Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газар, Нийслэлийн тээврийн газар, “Улаанбаатар смарт карт” ХХК болон бусад холбогдох байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгууллаа			√	
27.	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Үр дүнтэй нийгмийн халамжийн системийн чадавхи бэхжүүлэх нь ТТ 9893-МОН” төслийн хаалтын хурлын арга хэмжээг зохион байгуулав.			√	
28.	Ахмад настны үндэсний төвийн үйл ажиллагаа, цаашид анхаарах асуудлын талаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн Я.Цэлмэнтэй ажил хэргийн уулзалт зохион байгуулж, Олон улсын ахмадын эрхийг хамгаалах өдрийг угтаж тус төвд зохион байгуулах арга хэмжээний удирдамж, хөтөлбөрийг боловсруулав.			√	
29.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хөгжлийн төвийг хөгжүүлэхэд боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр шаардлагатай дэмжлэг үзүүлэх асуудлаар санал боловсруулан ЭМЯ, БШУЯ-т хүргүүлэв. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахтай холбоотой харьяа байгууллагууддаа чиглэл өгч ажиллах асуудлыг тусгав.			√	
30.	ХНХЯ-наас нийслэлийн Чингэлтэй дүүргийн 149 дүгээр сургуультай хамтран хэрэгжүүлсэн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй сургуулийн загвар төсөл”-ийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх асуудлаар БШУЯ-нд санал хүргүүлэв.			√	
31.	НҮБ-ын санхүүжилтээр Түгээмэл хөгжил бие даан амьдрах төвийн хийж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг орон сууцжуулахтай холбоотой төрийн бодлого шийдвэр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхцөл байдлын талаарх судалгаа”-ны асуумжтай уншиж танилцан санал хүргүүлэв.			√	
32.	ХНХЯ, МХАҮТ, АОЭНХ-той хамтран байгуулсан санамж бичгийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд тус байгууллагууд руу хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг /эх/-ийн ажлын цагт уян хатан зохицуулалт хийхтэй холбоотой санал боловсруулж, хүргүүлээ.			√	
33.	Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хамтран ажиллах санал боловсруулав.			√	
34.	Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрнаас үзүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй болгоход чиглэсэн нийгмийн ажилтны албан хэрэгцээнд зориулсан удирдамжийг боловсруулав.				√
35.	Өрх, гэр бүлийн статистик мэдээллийн агуулга, статистикийг 2018-2021 оны байдлаар гаргав.			√	
36.	Зорилтот бүлгийн залуучуудын хөгжлийг дэмжих хүрээнд хорих ангиас суллагдаж буй залуучуудыг нийгмийн харилцаанд ухамсартайгаар бие даан оролцох, өөрт холбогдох шийдвэрийг бие даан гаргах чадварыг эзэмшүүлэх “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр”-ийг ХНХСайд, ХЗДХСайд нарын 2022 оны А/167, А/233 дугаар хамтарсан тушаалаар баталсан. Хөтөлбөрийг танилцуулах, хамтын ажиллагааг дэмжих уулзалтыг 09 сарын 21-ний өдөр зохион байгуулав. Уулзалтад нийт 100 гаруй оролцогч цахимаар оролцсон. Хөтөлбөр хэрэгжсэнээр тухайн жилд суллагдсан залуучуудын 70-аас доошгүй хувийг сургалтад хамруулж, 50-аас доошгүй хувийг ажлын байраар хангаж, дахин гэмт хэрэгт холбогдолтыг 10-с доошгүй хувиар бууруулахыг зорьж байна.			√	
37.	НҮБ-ын “GenU” болон “Decent jobs for youths” санаачилгад Монгол Улс нэгдэхтэй холбогдуулан “Залуучуудын төлөө Монгол Улсын төрийн болон түншлэгч байгууллагууд, өсвөр үеийнхэн, залуучуудын хамтын ажиллагааны үнэлгээ”-г гүйцэтгэсэн. Өсвөр үе, залуучуудад мэдлэг, ур чадвар олгож төлөвшүүлэн, зохистой, үр бүтээлтэй ажилд бэлтгэх; энтрепренершилийн сэтгэлгээгээр орлогоо нэмэгдүүлэх боломж олгох; залуучуудад тулгамдаж буй асуудлаар шийдвэр гаргах үйл явцад холбогдох байгууллагууд, иргэний нийгэм, өсвөр үеийнхэн, залуучууд, олон нийтийн оролцоог хангахад чиглэсэн арга хэмжээний хөтөлбөрийг үнэлгээнд суурилан боловсруулав. Үнэлгээний тайлан, хөтөлбөрийн төслийг танилцуулах уулзалтыг 09 сарын 20-ны			√	

	өдөр төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, оюутан залуучууд зэрэг олон талын төлөөллийг хамруулан зохион байгууллаа.				
38.	Өвөрхангай аймгийн Хужирт, Хархорин, Арвайхээр сумд дахь Амьдрах ухааны сургалтын төвийг байгуулсан байдалтай танилцах, мэргэжил, арга зүйгээр хангах, аймгийн ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нийгмийн ажилтнууд, Залуучуудын хөгжлийн төвийн ажилтнуудыг Амьдрах ухааны модуль сургалтын шинэчилсэн хөтөлбөрийн дагуу сургагч багшаар бэлтгэх арга хэмжээг 10 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэл хангаад байна.			√	
39.	Залуучуудын хөгжлийн төвийн ажилтнуудыг залуучуудын хөгжлийн арга хэмжээ, үйлчилгээний шинэ тутам боловсруулагдсан болон батлагдсан бичиг баримтуудтай танилцуулах, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх, төвийн арга хэмжээ, үйлчилгээний чанар, агуулга, хүртээмжийг дээшлүүлэх, өсвөр үе, залуучуудыг чанартай үйлчилгээ, зөвлөгөө, мэдээллээр хангах, төвийн тогтвортой үйл ажиллагааг бэхжүүлэх зорилгоор мэргэшүүлэх сургалтыг 10 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган сургалтын удирдамж, хөтөлбөр, төсвийн тооцооллыг боловсруулаад байна.			√	
40.	Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлсэн байдлыг дүгнэх шалгуур үзүүлэлтийн төслийг боловсруулав.			√	
41.	Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын холбогдох албан тушаалтнууд “Монголын хүүхдийн сан” асрамж, халамжийн төвд ажиллаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.			√	
42.	Хүүхэд, залуучуудын статистикийн үзүүлэлт тооцох аргачлалыг ҮСХ-ны арга зүйн зөвлөлөөр хэлэлцүүлэв.			√	
43.	“Бага насны хүүхдийн цогц хөгжил” арга хэмжээний төслийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын холбогдох асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд танилцуулж, санал авав.			√	
44.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар “Хүүхэд, залуучуудын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал, мэдээлэл цуглуулах маягт, маягтыг нөхөх зааврыг шинэчлэн боловсруулах” чиг үүрэг бүхий ажлын хэсгээс Хэнтий аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран 2022 оны 09 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд уг зааврын төслийг танилцуулж, санал авах, аргачлалын зорилго, хүрээ, зарчмын талаарх мэдлэг, чадвар эзэмшүүлэх, сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Сургалтад Хэнтий аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Соёл, урлагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Улсын бүртгэлийн хэлтсийн холбогдох албан хаагчид, зарим Хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан оролцлоо.			√	
45.	Боловсролын орчин дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын судалгааны ажлыг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Судалгааны ажлын хэсгийн тушаалыг батлуулж, судалгааны ажлыг эхлүүлэв.			√	
46.	“Бага насны хүүхдийн цогц хөгжил” арга хэмжээний төслийг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон харьяа байгууллагын холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан салбарын хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэн боловсруулж, ажлын хэсгийн хуралдаанд танилцуулав.			√	
47.	“Жендэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар шинэчлэн батлав.			√	
48.	АНУ-ын Тусламжийн байгууллага, НҮБ-ын Хүүхдийн Сангийн дэмжлэгтэйгээр Онцгой байдлын ерөнхий газартай хамтран “Гамшиг, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал” үндэсний сургалтыг 2022 оны 09 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 115 хүнийг хамруулав. Сургалтаар “Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS 6948:2021 стандарт”-ын дагуу мэргэжлийн ангийн гишүүд гамшигийн үед авах арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх арга зүйн зөвлөмжийг өгөв.			√	
49.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/180 дугаар тушаалаар “Хүүхэд харах үйлчилгээний шалгуур, болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталж, нөлөөллийн шинжилгээний хамт захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.			√	

III	Бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр			√	
50.	Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороо байгуулаагүй 14 аймагт Хорооны бүрэлдэхүүний нэрс ирүүлэх тухай албан бичгийг 2022 оны 9 дүгээр сарын 28-ны 03/2441 албан бичгээр хүргүүлэв.				
51.	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Нийгмийн даатгалын шинэчлэл хийж, иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломж бүхий олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих зорилтот ажлуудын хүрээнд Европын Холбооны TAIEХ (Европын Комиссын Техникийн туслалцаа, мэдээлэл солилцох) төсөлтэй 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөөг 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр байгуулж хуучин социалист байсан зарим улсын нийгмийн даатгал ба тэтгэврийн тогтолцооны шинэчлэлийн талаарх сургалт хэлэлцүүлгийг 2022 оны 09 дүгээр сарын 12-14-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Энэхүү сургалтад Улсын Их Хурлын Тамгын газар, Нийгмийн бодлогын байнгын хороо, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, ХНХЯ, СЯ, МҮЭХ, Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Их сургуулийн багш, судлаачид, хувийн хэвшлийн төлөөлөл хүрэлцэн ирж мөн цахимаар Нийслэлийн нийгмийн даатгалын газар, 21 аймаг, 9 дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга нар, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооны 4 аймгийн төлөөлөл нийт 100 гаруй хүн оролцов.			√	
53.	“Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөнөөр тооцох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”-ыг шинэчлэн батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд яамдаас санал авахаар 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 01/2354 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлэв.			√	
54.	Монгол Улсад протез, ортопедын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг бэлтгэх, цаашид авах арга хэмжээний талаар салбар дундын хэлэлцүүлэг зохион байгууллаа. Германы “Human study” төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулагч Профессор Кристиан Шлиеф нь Монгол Улсад чанартай протез, ортопедын үйлчилгээг тогтвортой байлгах, ажиллах хүчийг чадавхижуулах, бэлтгэх чиглэлээр ажиллаж байна.			√	
55.	Олон Улсын Валютын Сангийн суурин төлөөлөгчийн газрын болон Монгол Улсыг хариуцсан эдийн засагч, багийн ахлагчтай тэтгэврийн шинэчлэлийн асуудлаар уулзалт хэлэлцүүлгийг 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгууллаа.			√	
56.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хороо 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр хуралдав. Хурлаар “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-г дахин судалж сайжруулах, “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны олон улсын стандартыг жижиг, дунд үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд зориулсан зөвлөмж”-ийг нэвтрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах бүртгэлийн гэрчилгээ шинээр авах болон төрөл нэмүүлэх байгууллагуудад гэрчилгээ олгох асуудлуудыг хэлэлцэв.			√	
57.	Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар ХНХ-ын сайдын 2022 оны А/170 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулав.			√	
58.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд эрүүл мэндийн салбарт улсын үзлэгийг МХЕГ-тай хамтран баталсан удирдамжийн дагуу зохион байгуулж байна.			√	
59.	Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан Эрүүл Мэндийн Яам, Хүний Эрхийн Үндэсний Комисстэй хамтран Ахмад настны үндэсний төвд өдөрлөг зохион байгуулахаар төлөвлөн удирдамж, хөтөлбөр боловсруулав.			√	
60.	Төрөлжсөн асрамжийн чиглэлээр гарах захиргааны статистик маягтын нөхөх зааврын төслийг боловсруулж, асрамжийн газруудаас туршилтын судалгаа авч байна.			√	
61.	Ахмад настны үндэсний төвийн асруулагчдыг Төв аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран Эрт илрүүлэг арга хэмжээнд хамрууллаа. Эрт илрүүлгийн хүрээнд тус төвийн 140 асруулагчид насны бүлгээр холбогдох шинжилгээ, оношилгоог хийлгэв.			√	
62.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ-ын уулзалтыг зохион байгуулж, шийдвэрлэх арга хэмжээний талаархи санал боловсруулан, ЭМЯ,			√	

	БШУЯ, ХБХХЕГ хүргүүлэв. Тус уулзалттай холбоотойгоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисст чиглэл хүргүүлэх тухай төслийг боловсруулж байна.				
63.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 33 дугаар тэмдэглэлийн биелэлтийг гаргах зорилгоор ЭМЯ, БШУЯ, БХБЯ, 21 аймаг, 9 дүүргийн мэдээллийг нэгтгэн боловсруулж байна.			√	
64.	ХНХССИ-тэй хамтран хийх “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах ойлголт, хандлага, нөхцөл боломж” судалгааны ажлын холбогдох албан тушаалтан төрийн бус байгууллагуудын саналыг авч, судалгааны загварыг боловсруулж байна.			√	
65.	Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороонд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж, амьдрах орчин нөхцлийг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх тайлан, мэдээллийг боловсруулж хүргүүллээ.		√		
66.	Өрхийн нэгдсэн мэдээллийн санг удирдах, ашиглах журмыг боловсруулах дэд ажлын хэсгийн хүрээнд уулзаж, санал авч эхний байдлаар журмын төслийг боловсруулав.			√	
67.	Үндэсний статистикийн хорооны даргын 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/139 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсэг болон тус яамны салбарын мэдээллийн технологи хариуцсан ахлах шинжээч Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын хөдөлмөр болон халамжийн мэдээллийн сангийн өгөгдлийн чанар, бүртгэл, мэдээллийн программ хангаж, Үндэсний статистикийн хороонд ирүүлж буй тоон мэдээллийн тооцооллын үнэн бодит байдалд хяналт хийх, бүртгэл тайлан хүлээн авах, нэгтгэн боловсруулах программ хангамжтай танилцав. Энэ хүрээнд мөн ГТСМТТ-ийн ehalamj мэдээллийн сангаас гарч буй статистик мэдээллийн тооцоололтой танилцлаа.			√	
68.	Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд олон улсын зөвлөхөөр хэтийн тооцоолол хийлгэхэд шаардлагатай тоон мэдээллийг авах хүснэгтийг боловсруулж, хүн ам, макро эдийн засаг, даатгалын сүүлийн 5 жилийн статистик мэдээллийг нэгтгэн боловсруулж байна.			√	
69.	Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд зохион байгуулсан үзэсгэлэнд ашиглагдах ХНХЯ-ны голлон ажиллаж буй томоохон төсөл хөтөлбөрүүдийг нэгтгэсэн тайлан мэдээ, харьяа байгууллагуудын цахим мэдээллийн санг таниулах QR CODE /ширээний/, постер, баннер, танилцуулга бэлтгэн техникийн дэмжлэг үзүүлж ажиллав.			√	
70.	Хүүхдийн статистикийн шинэчлэн боловсруулж буй аргачлалыг холбогдох салбарын хүүхдийн асуудал эрхэлсэн албан хаагчдад танилцуулж, мөн хүүхдийн статистикийн ерөнхий мэдээлэл бүхий 2022 оны товхимол боловсруулж байна.			√	
71.	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон төрөлжсөн асрамжийн халамжийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх төсөл хэрэгжихтэй холбоотойгоор АХБ-ны зөвлөх Жош Ашиштай уулзалт хийж төслийн талаарх мэдээллийг өгч, санал солилцов.			√	
72.	Хөдөлмөрийн зэх зээлийн eJob системийн хөгжүүлэлтэй холбоотойгоор системийн тест болон гар утсанд зориулсан аппликейшны эхний хувилбаруудтай танилцаж санал өгөв.			√	